

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААНУУР СУМЫН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Биелэлт	Хувь
1	2	3	4	5		
НЭГ. “КОВИД-19” ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО						
<i>Зорилт: “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, орон нутагтаа өвчлөл гарахгүй байхад анхааран гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллах.</i>						
1	1	Коронавируст халдвар /Ковид-19/-с урьдчилан сэргийлэх, эмчлэх, вакцинжуулах арга хэмжээг зохион байгуулах, түүнд шаардагдах хөрөнгийг ЗД-ын нөөцөд тусган зарцуулах	Шаардагдах зардлын нэр төрөл, тоо хэмжээ, мөнгөн дүн	Сумын ЗД-ын захирамжаар шаардагдах зардлыг баталж шийдвэрлэнэ.	2022 оны 11 дүгээр сарын байдлаар Корона вирусийн халдварын тохиолдол 98 бүртгэгдсэн бөгөөд бүх иргэнийг эмчилгээнд бүрэн хамруулсан. Эрүүл мэндийн төвд халдвараас сэргийлэх болон эмчилгээнд шаардагдах 2 сарын эм, тарианы нөөцтэй байна.	100%
2	2	СЗДҮАХ 2021-2024 1.1.10. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед ажиллах хяналтын пост, хариуцлагатай эргүүл, жижүүрийг томилгоожуулан, тогтмол ажиллуулж хяналт тавих.	Ажиллах хүн хүч, нөөц	Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эргүүл постын үйл ажиллагаа хэвийн явагдаж хяналт тавигдсан байна.	Сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран иргэдэд Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх анхааруулга, зөвлөмжийг тогтмол өгч ажилласан. 2022 оны 1, 2 дугаар улиралд суманд гарсан малын гоц халдарт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд 28 хоногийн 24 цагийн 3 постыг ажиллуулсан.	100%

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1.Эрүүл мэнд

Зорилт: Эрүүл мэндийн бодлогыг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ.

3	1	СЗДҮАХ 2021-2024 2.1.1	Хүн амын дунд эрт илрүүлэг үзлэг, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урдчилан сэргийлэх оношлогоо шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	Үзлэг оношлогоонд хамрагдсан иргэдийн тоо	Иргэд үзлэг оношлогоонд хамрагдсан байна.	Сумын эрүүл мэндийн төвд 2022 оны жилийн эцсийн байдлаар дараах зорилтод насны иргэдийг эрт илрүүлгийн үзлэгт хамруулсан. Үүнд: -Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт - 1410 -Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт-1352 -Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт-517 -Хөх, умайн хүзүүний хорт хавдар эрт илрүүлэх үзлэгт-139 -0-17 насны хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгт-1736 иргэнийг тус тус хамруулсан.	100%
4	2	СЗДҮАХ 2021-2024 2.1.4.	Шинэ коронавируст халдварын дараах хяналт болон уушигны эмгэг илрүүлэх “ Эрүүл амьдралын төлөө хамтдаа ” үзлэг оношлогоог аймгийн ЭМГ-тай хамтран зохион байгуулна.	Үзлэг оношлогоонд хамрагдсан иргэдийн тоо	Иргэд үзлэг оношлогоонд хамрагдсан байна.	Аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран 9 дүгээр сарын 7,8-ны өдрүүдэд 2 өдрийн хугацаанд Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг зохион байгуулсан. Үзлэгээр аймгаас сүрьеэгийн эмч, Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, ЭМТҮЧАБ хариуцсан дарга, рентген эмч, техникч, жолооч гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан. Сүрьеэ туссан, тусаад эдгэрсэн, мөн туссан иргэний 1, 2 дугаар хавьтал, мөн зорилтот бүлгийн 150 иргэний мэдээллийг гаргаж, 2 өдрийн хугацаанд цээжний рентген шинжилгээнд хамруулж, сүрьеэ хариуцсан нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгүүлж, өөрчлөлттэй гарсан иргэнээс цэрний шинжилгээ авсан. Үзлэгээр зорилтот бүлгийн 208 иргэн хамрагдсанаас 9 иргэн өөрчлөлттэй гарч, цэрний шинжилгээнд хамрагдсан.	100%

5	3	САХЖТ 31.11. СЗДҮАХ 2021-2024 2.1.10	Эрүүл мэндийн төвийн 15 ортой өргөтгөлийн барилгын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийнэ.	Ашиглалтад орсон барилга	ЭМТ-ын өргөтгөл баригдсан байна.	Эрүүл мэндийн төвийн 15 ортой өргөтгөлийн барилгын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр "Девсофт ХХК" шалгаран хийж эхэлсэн бөгөөд ажлын явц 50 хувьтай байна. Ажил 2023 онд үргэлжлэн явагдах бөгөөд улсын төсөвт нийт 513 сая төгрөг батлагдсан. 2023 онд аймгийн хөрөнгө оруулалтаар эмнэлгийн барилгын санхүүжилтэд 320.0 сая төгрөгийг батлуулсан.	100%
6	4	СЗДҮАХ 2021-2024 2.1.11.	Эмнэлгийн бохирын шугамын засварын ажлыг холбогдох байгууллагаар хийлгэнэ.	Засварын ажлын чанар стандарт	Засварын ажил хийгдсэн байна.	Эмнэлгийн бохирын шугамын засварын ажлыг сумын ОНХСангийн хөрөнгө 29,8 сая төгрөгөөр "Хүнх сэрвэн ХХК" 100 хувь хийж гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.	100%
7	5	СЗДҮАХ 2021-2024 2.1.8	Шүдний кабинеттай болох асуудлыг шийдвэрлэнэ.	Шинээр тавигдах тоног төхөөрөмжийн тоо	Шүдний кабинет, тоног төхөөрөмжтэй болсон байна.	2022 онд "Атартрейд" ХХК, МУ-ын арслан Б.Орхонбаяр нар хамтран сумын Эрүүл мэндийн төвд 23.0 сая төгрөгийн өртөг бүхий шүдний кабинтын иж бүрэн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.	100%
2.2.Боловсрол							
<i>Зорилт:Боловсролын байгууллагын орчин нөхцөлийг сайжруулж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.</i>							
8	1	САХЖТ 170.5. СЗДҮАХ 2021-2024 2.2.8	Улсын төсвийн хөрөнгөөр баригдах сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн ажлыг эхлүүлэх	Ашиглалтад орсон барилга	Сургалтын таатай орчин бүрдэж, хүүхэд бүр сурч,, хөгжих таатай орчин бүрдэнэ.	Улсын төсвийн хөрөнгөөр баригдах 320 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийн барилгын ажилд "Асуд констракшн ХХК" шалгарч, барилгын шугамын ажил хийгдсэн. 2023 оны улсын төсөвт 1 тэрбум 930 сая төгрөг батлагдсан.	100%
9	2	САХЖТ 9.1. СЗДҮАХ 2021-2024 2.2.3	Бага дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдолыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Бага, суурь, бүрэн дунд боловсролын шалгуурт суурилсан шалгалт, хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэлийн хувь	Суралцагчдын сурлагын амжилт өссөн байна.	Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 47 багш хамрагдсан ба 1 дүгээр түвшинд 4 багш, 2-р түвшинд 17, 3 дугаар түвшинд 26 багш үнэлэгдсэн Суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний дагуу бага боловсролд "Тоглонгоо суралцъя" төсөл амжилттай хэрэгжиж байна. Дунд ахлах ангиудад хоцрогдол арилгах чиглэлээр давтлага, сургалт, сургалт дэмжих мэдлэг сорих тэмцээн, мэдлэг чадварыг үнэлэх	100%

						оношилгооны дараа хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанууд тогтмол явагдсаар байна.	
10	3	САХЖТ 11.3. СЗДҮАХ 2021-2024 2.2.2	“Чадварлаг багш” хэмжээг хэрэгжүүлэх	арга	Мэдлэг чадвара дээшлүүлсэн багшийн тоо	ур Арга хэмжээ хэрэгжсэн байна.	100%

БМДИ-ийн анхны жилийн сургалтад 2 багш цахимаар хамрагдаж амжилттай суралцсан. Мэргэжлийн бүлгийн сургалтад цахимаар 2 удаа давхардсан тоогоор 12 багш, арга зүйч хамрагдсан. БМДИ-ийн сайжруулсан сургалтын хөтөлбөрийн болон сурлагын хоцрогдол арилгах сургалтад 6 багш 1 арга зүйч, ОУ-ын "Эко сургууль, цэцэрлэг" Мөнгөн гэрэгэ хөтөлбөрийн 3 дахь шатны сургалтад танхимаар 3 удаа нийт 15 багш /давхардсан тоогоор/ сурсан. Түүнчлэн ажлын байрандаа цэцэрлэгийн захиргаанаас болон ЗАН-ээс 11 удаа арга зүй, ёс зүй, харилцааны сургалтуудыг зохион байгууллаа. Аймгийн БШУГ-аас зохион байгуулан явуулж буй “Багш миний туршлага” сэдэвт арга зүйн сургалт 2022 оны 3, 4 дүгээр сард нийт 6 удаа чиглэл тус бүрээр зохион байгуулагдан явагдсан. Уг арга хэмжээнд нийт багш нараа бүрэн хамруулан оролцуулж багш нарын заах арга ур чадварыг дээшлүүлэн ажиллаж байна. БМДИ, аймгийн боловсролын газар, сум орон нутаг, байгууллагаас зохион байгуулсан нийт 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 144 багш хамрагдсан. БМДИ-ийн СӨБ-ын байгууллагын удирдах ажилтны хөгжил хариуцсан арга зүйч багшийн "Тэгш хамруулан сургах боловсролын эрх зүйн орчин", "Боловсролын харилцаа-Багшийн нөлөөлөл", БМДИ-ийн багшийн "Зайн сургалтын онол арга зүй", Нийслэлийн СӨБ-ын мэргэжилтэн багшийн "СӨБ-ын баримтлах бодлого", боловсролын газрын мэргэжилтэн, эрхлэгч нарын хамтран зохион байгуулсан "Хөдөлмөрийн хууль-Хөдөлмөрийн гэрээ", "Мэргэжлийн зэрэг олгох хасах журам", "Хүүхэд хамгаалал", "Цэцэрлэг ЕБС-ийн үйл

						ажиллагааг үнэлэх, дүгнэх журам А\803 дугаар тушаал", "Байгууллагын хөгжлийн менежмент-Стратеги төлөвлөгөө боловсруулах арга" зэрэг сэдэвт сургалтуудад цахимаар хамрагдсан.	
11	4	СЗДҮАХ 2021-2024 2.2.10	СӨБ-ийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, хувилбарт сургалт, нүүдлийн цэцэрлэгийн үйлчилгээг малчин өрхийн хүүхдүүдийн дунд зохион байгуулна.	Хамран сургалтын хувь, цэвэр жин / өссөн дүнгээр/ Нүүдлийн цэцэрлэгийн тоо	СӨБ-ийн хамран сургалтын хувь хэмжээ, нүүдлийн цэцэрлэгт хамрагдах малчин өрхийн хүүхдийн тоо нэмэгдсэн байна.	СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2 дугаар цэцэрлэгээс малчин өрхийн хүүхдүүдэд нүүдлийн 2 бүлгийг 6 ба 7 дугаар саруудад 8 долоо хоногийн хугацаанд хичээллэж, СӨБ-д 60 хүүхэд хамрууж хамран сургалтын цэвэр жин 78.2%-д хүргэсэн. Мөн 1 дүгээр цэцэрлэгт 24 цагийн бүлэгт болон өдрийн бүлэгт нийт -43 малчин өрхийн хүүхэд суралцаж байгаа бөгөөд хамран сургах тойргийн малчдын зуслангийн газарт нүүдлийн цэцэрлэг ажиллуулж малчин өрхийн 18 хүүхдийг хамруулсан.	100%
12	5	СЗДҮАХ 2021-2024 2.2.14.	2-р цэцэрлэгийн гадна биеийн тамирын талбай байгуулна.	Шинээр хийгдсэн талбай, тоглоомын тоо	Биеийн тамирын талбай байгуулагдсан байна.	2023 онд хэрэгжихээр шийдвэрлэсэн	0
13	6	СЗДҮАХ 2021-2024 2.2.14.	2-р цэцэрлэгийн урлаг заалны хөгжим хэрэглэгдэхүүнтэй болно.	Шинээр нийлүүлсэн хөгжим, хэрэглэгдэхүүний тоо	Шинэ хөгжим хэрэглэгдэхүүнтэй болсон байна.	2023 онд хэрэгжихээр шийдвэрлэсэн	0
2.3. Биеийн тамир, спорт							
<i>Зорилт:Хүн амын нийтийн биеийн тамираар хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.</i>							
14	1	СЗДҮАХ 2021-2024 2.3.1	Сумын иргэдийн дунд спортын уралдаан тэмцээн, сумын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулна.	Биеийн тамираар хичээллэгчдийн тоо	Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо нэмэгдэнэ	Иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн оролцоог сайжруулах, суманд олон төрөлт спортыг хөгжүүлэх зорилгоор 3 дугаар сард сумын аварга шалгаруулах волейбол, сагсан бөмбөгийн тэмцээн, 10-р сард Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 3 төрлөөр, Аймгийн ахмадын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 4 төрлөөр, Багш нарын баярын өдөрт зориулан волейболын тэмцээн, 11 дүгээр сард	100%

						Хөдөө аж ахуйд ажиллагсадын баярын өдөр, Монгол Улсын арслан Б.Орхонбаярт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хүрээнд Волейболын тэмцээн тус тус зохион байгуулж нийт давхардсан тоогоор 520 орчим иргэн хамрагдаж оролцсон байна.	
15	2	СЗДҮАХ 2021-2024 2.3.3	Спорт цогцолборыг түшиглэн хүүхэд залуучуудын дунд секц дугуйлан ажиллуулна.	Клуб дугуйлан секцэд хичээллэгсдийн тоо	Хүүхэд залуучууд секц дугуйланд хамрагдсан байна.	Спорт цогцолборт 6 төрлийн секц дугуйлан хичээллэж нийт 120 гаруй хүүхдүүд хамрагдаж байна.	100%
16	3	СЗДҮАХ 2021-2024 2.3.5	Спорт цогцолборын барилгын засварын ажлыг аймгийн хөрөнгө оруулалтаар хийнэ.	Засварын ажлын чанар стандарт	Зураг төсөв чанартай хийгдсэн байна	Спорт цогцолборын барилгын засварын ажлыг аймгийн ОНХСангийн хөрөнгө 297,5 сая төгрөгөөр “Дээдсийн жигүүр ХХК” шалгаран ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.	100%
17	4	СЗДҮАХ 2021-2024 2.3.7.	Улс, аймаг, бүсийн хэмжээнд зохиогдох спортын уралдаан тэмцээнд хүүхэд, залуучуудыг оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.	Спортын тэмцээний хамрах хүрээ, тоо Улс, аймгийн тэмцээнд гаргасан амжилт	Улс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд иргэд оролцсон байна.	Сэлэнгэ аймгийн “Нарт” сумо бөхийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон нийт 7 тамирчинд дэмжлэг үзүүлэн оролцуулсан ба тамирчид амжилттай оролцож алт, хүрэл медаль хүртлээ. Бүх ард түмний XV спортын их наадамд 2 тамирчин сум орноо төлөөлөн оролцон, улсад ПАРАЖУДО-ын эмэгтэй 48 кг-ийн жинд Алтан медаль, эрэгтэй 100, 200 метрийн гүйлтийн тэмцээнд Хос алтан медаль хүртсэн Тамирчдыг сумын Засаг дарга баяр хүргэн шагнаж урамшуулсан.	100%
18	5	СЗДҮАХ 2021-2024 2.3.8	Бүсийн сумдын төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд спортын нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулна.	Зохион байгуулагдсан тэмцээн уралдааны тоо, хамрах хүрээ	Бүсийн сумдын хамтын ажиллагаа дээшилсэн байна.	Аймгийн аварга шалгаруулах Софт волейболын ахмадын тэмцээнийг зохион байгуулсан ба 5 бүсийн 80 гаруй ахмад тамирчид оролцсон. Сэлэнгэ бүсийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын нөхөрсөг тэмцээнийг 6 төрлөөр Зүүнбүрэн суманд зохион байгуулж, багийн дүнгээр сумын ЗДТГ-ын албан хаагчид тэргүүн байр эзэлсэн.	100%
2.4. Соёл, урлаг:							
<i>Зорилт: Хүн амд үзүүлэх соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.</i>							
19	1	СЗДҮАХ 2021-2024	Сумын иргэд, байгууллагуудын дунд соёл	Хамрагдсан иргэд, хүүхэд	Соёл урлагийн үйлчилгээний	2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, 8 зорилтын хүрээнд 208	100%

		2.4.1	урлагийн арга хэмжээг төлөвлөгөө хэрэгжүүлнэ. гарган	залуучуудын тоо	хүртээмж нэмэгдэнэ.	ажил арга хэмжээг зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 10000 гаруй иргэнд соёл урлагийн үйлчилгээ үзүүлсэн. Соёлын төвөөс цахим болон танхимаар соён гэгээрүүлэх 58 удаагийн арга хэмжээ, номын сангаас уншигчдын дунд 118 арга хэмжээ, орон нутаг судлах танхимаас 18 арга хэмжээг зохион байгуулсан. “Сар шинийн эгшиглэн”, “Ээждээ баярлалаа”, “Бидний авьяас”, “Хуурчийн хүүхдүүд” зэрэг 3 уран бүтээлийн тоглолт болон хэсэгчилсэн тоглолт 8 удаа зохион байгуулсан. "Ургийн бичиг" хөтлөхийн ач холбогдолын талаар нийт 85 малчид, иргэдэд мэдээлэл өгч угийн бичиг хөтлөх аргачилал номыг танилцуулан 25 иргэнд ном өгсөн. “Үндэсний бичиг соёлын өдөр” –ийн хүрээнд Монгол үндэсний хэл бичгээрээ цэвэр сайхан бичих сурч эзэмших хүсэл эрмэлзлийг бадраах, хөхүүлэн дэмжих, бичих унших чадварыг нэмэгдүүлэх зорилгоор уран бичлэг, уншлагын 5 удаагийн уралдаант арга хэмжээг зохион байгуулсан. Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд: “Босоо Монгол бичиг мину” сургааль ,зүйр цэцэн үгсийн уран бичлэгийн уралдааныг хүүхэд, насанд хүрэгчид гэсэн 2 насны ангилаар зохион байгуулан нийт 14 хүүхэд 8 насанд хүрэгчид оролцлоо.	
20	2	СЗДҮАХ 2021-2024 2.4.3	Соёлын төвийн шинэ барилгын ажлын зураг төсвийг холбогдох байгууллагатай хамтран хийх.	Зураг төсөв хийлгэхээр хандсан мэргэжлийн байгууллага, тоо	Зураг төсөв хийгдсэн байна.	Шинээр соёлын төвийн барилга барих саналыг УИХ-н гишүүн холбогдох удирдлагуудад хүргүүлж нэгдсэн зураг төсвийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр Соёлын яамны тэргүүлэх чиглэлд тусгасан.	30%

21	3	СЗДҮАХ 2021-2024 2.4.3	Сумын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хамгаалуулах	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалсан тоо	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн хуулийн этгээдээр хамгаалуулсан байна.	Сумын Засаг даргын А/124 захирамжаар 18 иргэн, ААН-д 153 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг хариуцан хамгаалах гэрээг шинэчлэн байгуулсан. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллогоор сумын нутаг дэвсгэрт байгаа улсад бүртгэлтэй 207 ширхэг түүх, соёлын дурсгалт зүйлс, газрыг тооллогод хамруулсан. Тооллогын үеэр сумын Атар, Сангалтай гэх газарт орших 1 зосон зураг, Нарийн шүрэнгийн 4 хиргисүүр, Хуурчийн хөндийд байрлах 8 ш дөрвөлжин болон дугуй булшийг олж, бүртгэн баримтжуулж авсан.	100%
22	4	СЗДҮАХ 2021-2024 2.4.3	Соёлын төвийн цэвэр усны шугамыг засварлах ажлыг холбогдох байгуулагуудтай хамтран шийдвэрлэх	Гүйцэтгэлийн хувь	Цэвэр усаар хангагдсан байна.	Хэрэгжээгүй	0
23	5	СЗДҮАХ 2021-2024 2.4.8.	Аймгийн хөрөнгө оруулалтаар соёлын төвийг лед дэлгэцээр хангах ажлыг хэрэгжүүлнэ.	Гүйцэтгэлийн хувь	Лед дэлгэцтэй болсон байна.	Хэрэгжээгүй	0
2.5.Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого							
Зорилт:Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжиж, иргэн бүрт хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгоно.							
24	1	СЗДҮАХ 2021-2024 2.5.1	Суманд хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын талаар баримтлах бодлогыг гаргаж хэрэгжүүлж ажиллана.	Батлагдсан бодлого зорилтын тоо	Бодлогын баримт бичиг батлагдаж, хэрэгжсэн байна.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар бодлогын баримт бичгийг батлуулаагүй. Сумын ахмадын холбоо нь нийт ахмадын дунд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө Засаг даргаар батлуулан Засаг даргын нөөц хөрөнгөөс 1000.0 мянган төгрөгийн санхүүжилт аван тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Ахмадын холбоо нь дарга Тэргүүлэгчдээ шинэчлэн томилж ЗДТГ-тай идэвхтэй хамтран ажилладаг.	50%
25	2	СЗДҮАХ 2021-2024 2.5.2	Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж иргэд, олон	Зохион байгуулсан нөлөөллийн ажил	Гэр бүлийн амар тайван аюулгүй амьдрах орчин бүрдэнэ.	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг	100%

			нийтийн оролцоог нэмэгдүүлнэ	хамрагдсан байгууллага, иргэдийн тоо		нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын төвийг тойрсон хатуу хучилттай зам дагуу 3 ширхэг нөлөөлийн самбар байрлуулсан. Самбараар дамжуулан гэр бүлийн хүчирхийлийн дуудлага мэдээллийг хүлээн авах утсуудыг сурталчилсан бөгөөд ингэснээр 108 дугаарын утасны талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж хүчирхийлэл үйлдэх гэж байгаа болон үйлдсэн этгээдүүдийг түргэн шуурхай илрүүлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдээд байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж сумын хамтарсан баг сумын хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нийт 21 кейсийг шийдвэрлэж ажилласан.	
26	3	СЗДҮАХ 2021-2024 2.5.4	Хүүхдийг болзошгүй эрсдэл, осол гэмтэл, гэмт хэрэг, цахим орчны нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээний тоо Хамрагдсан хүүхдийн тоо	Хүүхдүүд гэмт хэрэг, осол гэмтэлд өртөх эрсдэл буурсан байна.	СӨБ-ийн багш нараар дамжуулан “Гар утас тоглоом биш” гарын авлагыг 5 удаагийн үйл ажиллагаагаар 970 эцэг эх, асран хамгаалагчдад, “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх арга аргачлалыг түгээн дэлгэрүүлэх” сургалт нөлөөллийн ажил, “Цахим хэрэгсэлд донтох, донтолтын хор нөлөө” сэдвээр сургалт, мэтгэлцээн, “Дэлгэцийн донтолт ба Гэр бүлийн анхаарал” сэдвийн хүрээнд багш эцэг эхийн хамтарсан 2 баг хүүхдүүдэд жүжигчилсэн тоглолт, “Дэлгэцтэй биш, дэлгэсэн номтой нөхөрлөө” цуврал сургалт, “Гар утас хүүхэд аргадах тоглоом биш” сэдэвт сургалт, “Дэлгэцийн донтолтоос сэргийлж эрүүл мэндээ хамгаалцгаая” аяны хүрээнд “Спортлог гэр” бүл өдөрлөг зэргийг зохион байгууллаа. сургалтуудад давхардсан тоогоор 1100 эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид, сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг хамруулсан.	100%
27	4		Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга сургалтыг зохион байгуулна	Сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэгтэй болсон	Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг” сэдэвт сургалт, 6-11 дүгээр ангийн сурагчдад “Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт” сургалт, 6-12	100%

					байна.	дугаар ангийн хөвгүүдэд “Хорт зуршил” сургалтуудыг явуулж давхардсан тоогоор 812 эцэг эх, асран хамгаалагч, сурагчдыг хамруулсан. Мөн гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй хүүхдүүдийн 37 эцэг эх, асран хамгаалагчтай нийгмийн ажилтан уулзаж, ярилцлага хийж, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан . Сумын хамтарсан баг архины хамраалалтай айл өрх, хүчирхийлэлтэй айл өрх нийт 19 гэр бүлд очиж үйлчилгээ үзүүлсэн.		
28	5		Хүүхэд хамтарсан чадавхжуулна.	хамгааллын багийг	Кейсийн тоо	Гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн тоо буурсан байна	Аймгийн гэр бүлийн газрын ажилтан болон цагдаагийн газрын алба хаагч нартай 2 удаа сургалт зохион байгуулж мэдээлэл солилцон хамтран ажилласан. Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ГБХЗХГ-аас зохион байгуулагдсан НАМС-ын сургалт, НБХМэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, “Хүүхэд хамгааллын кейс менежмент”, “НАМС-ыг ашиглах нь” зэрэг сургалтуудад хамрагдсан. Хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчилах, хамтран ажиллахад хүн бүрийн оролцоо маш чухал гэдгийг сурталчлах зорилгоор сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг” сургалтыг зохион байгуулсан	100%
29	6	СЗДҮАХ 2021-2024 2.5.8	Жендерийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт сурталчилгаа, ажлыг өрнүүлэх	нөлөөллийн	Нөлөөллийн ажил хамрагдсан байгууллага, иргэдийн тоо	Иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлж, хандлагыг өөрчилнө.	Сумын төрийн байгууллагуудын ажилтнуудын судалгааг гаргасан. Эрүүл мэнд, Боловсролын байгууллагууд ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэг хүйсийн ажилтнууд давамгайлах хандлагатай. ЗДТГ-т хүйсийн харьцаа тэнцвэртэй байна. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярын “Хандлагаа өөрчилж, хамтдаа хөгжье” эмэгтэйчүүдийн чуулга уулзалт, “Бүсгүйчүүд” уралдаант тэмцээн зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд Лектор Н.Алтанцоож “Харилцаа” сэдэвт сэтгэл зүйн сургалт, “Охидын дуу хоолой”, “Эмэгтэйчүүдэд	70%

						тулгамдаж байгаа асуудал – шийдэл” хэлэлцүүлэг боллоо.	
30	7	ИТХ-н санал	Сумын залуучуудын чуулга уулзалт зохион байгуулж, хамтран ажиллана.	Уулзалт зохион байгуулагдсан эсэх	Чуулга, уулзалт зохион байгуулагдсан байна.	Монголын Залуучуудын өдрийг тохиолдуулан "Хүртээмжит нийгэм-залуусын оролцоо-хөдөлмөр эрхлэлт" залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд "Орон нутгийн залуусаа сонсьё" хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр төрөөс залуучууд руу чиглэсэн бодлого чиглэл, сум орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар товч мэдээлэлийг залуучуудад өглөө. Мөн Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн танилцуулга, түүнтэй уялдан орон нутгийн зүгээс залуучуудыг дэмжих чиглэлээр баримталж буй бодлого, хийгдэж буй ажил, хөтөлбөрийн талаар, Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, элдэв өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар, Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар статистик тоон мэдээлэл, хөдөлмөр эрхлэгч залуучуудыг дэмжих төсөл хөтөлбөрийн танилцуулга мэдээллийг хүргэлээ. Чуулганы эцэст залуучуудын хөгжилд тулгамдаж буй асуудал - нээлттэй санал асуулга, хэлэлцүүлгийг явуулж, залуучуудаас гарсан санал хүсэлтийг хүлээн авлаа.	50%
2.6.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал.							
Зорилт:Нийгмийн халамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангана.							
31	1	СЗДҮАХ 2021-2024 2.6.3	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санг баяжуулж, ажилгүй иргэдийн тоог бууруулна.	Бүртгүүлсэн иргэдийн тоо	Мэдээллийн санд бүртгэгдсэн иргэд ажлын байранд зуучлагдсан байна.	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд нийт 152 иргэнийг бүртгэсэн. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийн LMIS программд идэвхтэй ажил хайгчаар 130 иргэн, ажил олгогч 45 ААН, шинэ ажлын	100%

						байранд 88 иргэн, зуучлалаар 83 иргэн бүртгэсэн.	
32	2	СЗДҮАХ 2021-2024 2.6.5. 2.6.6.	Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчид, оюутан, ажилгүй иргэдийг сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Хамрагдсан иргэдийн тоо, хувь /өссөн дүнгээр/	Сайн дурын даатгалын ач холбогдлыг иргэд, малчдад таниулснаар даатгуулагчийн тоо нэмэгдсэн байна.	2022 онд шинээр сайн дурын даатгалд хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчин 43 иргэн сайн дурын даатгуулж төлж эхэлсэн. Үүнээс малчин 27, 3 хүртэлх насны хүүхдээ асарч буй малчин эх 4, хувиараа хөдөлмөр эрхлэгч 12 иргэн хамруулсан.	100%
33	3	СЗДҮАХ 2020-2024 2.6.8	Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой болон зорилтот бүлгийн айл өрхүүдийн амьжиргааг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулна.	Хамруулсан өрхийн тоо, хамрагдсан төсөл хөтөлбөрийн тоо	Төсөл хөтөлбөрт хамрагдсан өрхийн амьжиргаа дээшилсэн байна.	ОНОТХҮйлчилгээнд 1 иргэнд 2 сая төгрөг олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 2 иргэнийг “Мах, сүү, цагаан идээгээ боловсруулах”, “Хоёрдогч түүхий эд боловсруулах” төслөөр 5 сая төгрөгийг 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгож үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байна. Мөн өрхийн зорилтот бүлгийн өрхийн амьжиргааг дэмжих зорилгоор гар урлалын дугуйланд 2 иргэнийг хамруулсан.	70%
34	4	СЗДҮАХ 2021-2024 2.6.9	Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай өрх иргэнийг халамжийн үйлчилгээнд хамруулна.	Нийгмийн халамжид хамрагдсан өрх, иргэдийн тоо	Халамж дэмжлэг шаардлагатай иргэд халамжийн үйлчилгээнд бүрэн хамрагдсан байна.	Зорилтот бүлгийн 22 өрхийн 52 том хүн, 72 хүүхдийг хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдаж байна.	100%
Гурав.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
3.1.Хөдөө аж ахуйн бодлого							
Зорилт:Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлнэ.							
35	1	СЗДҮАХ 2021-2024 3.1.2	Цагааннуур сумыг “Эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйн загвар” сум болгон хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулна.	Сумын ИТХ-аар батлагдсан эрх зүйн журам, зөвлөмж, бодлогын баримт бичгийн тоо	Газар тариалангийн бүс нутаг дахь газар тариалан, МАА-н харилцан үйл ажиллагаа сайжирна.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд газар тариалангийн бүсэд МАА эрхлэгчдэд батламж олгох журмын төслийг боловсруулан хүргүүлж батлуулсан. Энэ ажлын хүрээнд газар тариалангийн бүсэд үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах, ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 32	70%

						өрхийн 120 адуу, 1823 үхэр, 4862 хонь, 2073 ямаа, нийт 8878 малд үзлэг хийж, ангилалтын дүн мэдээг нэгтгэж хүргүүлсэн.	
36	2	СЗДҮАХ 2021-2024 3.1.3	Малчид, тариаланчдын хамтын ажиллагааг сайжруулж, зөвлөгөөнийг зохион байгуулна.	Зөвлөгөөнд хамрагдсан иргэдийн тоо, шийдвэр	Зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилт	2022 оны 05 дугаар сард Тариаланчдын зөвлөгөөн зохион байгуулсан. Зөвлөгөөнд суманд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэд ААН-ийн удирдлага, иргэд нийт 14 хүн оролцож, тариалалтын явц, нөхцөл байдал, тариаланчдын хамтын ажиллагааны уяалдаа холбоог сайжруулах талаар хэлэлцлээ. 2022 оны 08 дугаар сард Оргих 1, Тийрэг 3 дугаар багуудын өдөрлөгийн үеэр малчдад тариалангийн тухай хуулийн зарим зүйл заалтаас танилцуулсан.	70%
37	3	СЗДҮАХ 2021-2024 3.1.5	Тариалангийн талбайг хашсан хашааны эзэмшил, хамгаалалтыг сайжруулж, хашаажуулах ажлыг үргэлжлүүлнэ, тариалангийн бүс малчдын зусланг заагласан хашааг малчдын оролцоотойгоор барина.	Шинээр барьсан хашааны тоо хэмжээ	Тариалангийн талбайн хашааг эзэмшил, хамгаалалтад шилжүүлсэн байна	Тариалангийн талбайг хашсан хашааг тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй ААН, иргэдэд хуваарилах ажлыг зохион байгуулж дуусгасан. Нийт 150 км хашааг 39 иргэн, ААН-д хуваарилахаар болж 12 сард эзэмшүүлэх гэрээнд гарын үсэг зуруулахаар бэлэн болоод байна.	30%
38	4	СЗДҮАХ 2021-2024 3.1.6	Тариалан эрхэлж буй ААН, иргэдийн эзэмшиж буй тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, бордоо хэрэглэхэд хяналт тавьж ажиллана.	Бордоотой тариалалтын нэмэгдсэн хэмжээ	Нэгж талбайгаас авах ургацын хэмжээ нэмэгдсэн байна	2022 онд суманд газар тариалангийн үйл ажиллагаа явуулж буй ААНэгж, иргэдийн хэрэглэсэн ургамал хамгааллын бодис, бордооны дүн: Эдагум 2,8 тонн, гумат 2,54 тонн, белый жемчук – 2,68 тонн Адью -1,29 тонн хэрэглэж га-н дундаж ургац 15,5 цн буюу өмнөх онтой харьцуулхад 1,5 цн-р өссөн байна.	100%
39	5	СЗДҮАХ 2021-2024 3.1.9	Хүлэмжийн болон өвлийн хүлэмж зоорины аж ахуй эрхлэлтийг дэмжиж, шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.	Шинээр баригдсан хүлэмж, зоорины тоо	Хүлэмж, зоорины тоо нэмэгдэнэ.	2022 онд аймгийн хөрөнгө оруулалтаар сум бүрт 8*4 харьцаатай 1 ширхэг хүлэмж олгосон. Өвлийн хүлэмж байхгүй. Аймгийн ХАА-н газартай хамтран хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 5 хүлэмжийг суманд аваад байна. БНСУ-н дэвшилтэт	30%

						технологи бүхий ухаалаг хүлэмжийг бий болгохоор гэрээ хэлэлцээр хийгдсэн.	
40	6	СЗДҮАХ 2021-2024 3.1.12	Ногоочдод хүнсний ногоо тариалахад туслах тоног төхөөрөмжийн дундын парк бий болгох ажлыг аж ахуйн нэгж байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.	Паркийн тоо	Хүнсний ногооны тариалалт нэмэгдэнэ	2024 онд хэрэгжинэ	0
41	7	СЗДҮАХ 2021-2024 3.1.16	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх талаар сургалт сурталчилгаа, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж, эрчимжсэн жишиг малчин өрх бий болгоно.	Жишиг малчны тоо, сургалтын тоо	МАА эрхлэгчдийн жишиг өрх бий болно	08 дугаар сард Оргих, Тийрэг багуудын малчдын өдөрлөгийг зохион байгуулж, Газар тариалангийн бүсэд үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх ажлын хүрээнд хийгдэж буй ажлууд, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн. Уг ажлын үр дүнгээр эрчимжсэн, төрөлжсөн МАА эрхэлж буй 17 малчин өрх, 1 ААН-ийг цөм сүрэг бүхий малчин өрхийн батламж олгохоор аймгийн ХХААГ-т уламжилсан.	70%
42	8	СЗДҮАХ 2021-2024 3.1.17.	Суманд малын гаралтай түүхий эдийг боловсруулах цех бий болгож, уламжлалт аргаар арьс шир, ноос боловсруулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.	Түүхий эд боловсруулах цехийн тоо	Ажлын байр нэмэгдсэн байна	Санал гараагүй	0
43	9	СЗДҮАХ 2021-2024 3.1.22	Бэлчээрийн газрын ашиглалтыг сайжруулах журам боловсруулж хэрэгжүүлнэ.	Батлагдсан журмын тоо	Бэлчээр ашиглалт сайжирна	Бэлчээр ашиглалтыг сайжруулах зорилгоор 1 дүгээр багийн Нарангийн даваа болон Гэр чулууны давааг засварласан.	100%
44	10	СЗДҮАХ 2021-2024 3.1.13	Мал сүргийг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх эрүүлжүүлэх ажлыг графикт хугацаанд зохион байгуулж хяналтыг сайжруулна.	Гоц халдварт, халдварт өвчнөөр тайван байдлаа хадгалсан эсэх	Вакцин, тарилга туулгалтад бүрэн хамрагдсан байна.	Засгийн газрын 255 дугаар тотоолын 1, 2, 3 дугаар хавсралтад заагдсан өвчөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулсан. Төлөвлөгөөт вакциныг Аймгийн Мал эмнэлэгийн газраас татан авч, суманд үйл ажиллагаа явуулж буй 4 МЭҮН-үүдээр дамжуулан гэрээт өрхүүдийн малыг	100%

						<p>100 хувь хамруулан, мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөгөө гүйцэтгэл 100% оруулж хяналт тавин баталгаажуулсан.</p> <p>2022 онд нийт гоц халдварт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт 10 төрлийн тарилгад боом 36600 толгой, галзуу 4400 толгой, гахайн мялзан 2100 толгой, адууны томуу 1600 толгой, цусан халдварт 5400 толгой, дуут хавдар 8800 толгой, тугалын иж балнад 1065 толгой, ГЦХИБ 1500 толгой, шөвөг яр 42200 толгой, бактерин 1600 толгой мал амьтан тус тус хамруулсан.</p> <p>Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд сумын хэмжээнд нийт 24400 толгой үхэр, шүлхий өвчний вакцинд хавар, намар 2 удаагийн тарилгаар үхэр 52105 толгой, гахай 2236 толгой, хонь 23203 толгой, ямаа 19113 толгойг хамруулсан. Бруцеллээс өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад тугал 4400 толгой, хурга 23800 толгой, ишиг 16200 толгой охин төл хамруулсан.</p> <p>Угаалгад 136100 толгой, туулгалтад 116846 толгой, боловсруулалтад 95280 толгой, гуурын боловсруулалтад 14500 толгой мал амьтан тус тус хамруулж мал эмнэлгийн цахим системд төлөвлөгөө гүйцэтгэл 100% оруулж баталгаажуулсан.</p>	
45	1 1	СЗДҮАХ 2021-2024 3.1.13	Мал угаалгын ванн шинээр нэмэгдүүлнэ.	Ваннд угаасан малын тоо, чанар	Ваннтай болсон байх	Малын тоо толгойн албан татвар төвлөрөөгүй улмаас 2022 онд хэрэгжих боломж бүрдээгүй. Мал угаалгын ванн 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр зураг төсөв хийлгэсэн.	0
46	1 2	СЗДҮАХ 2021-2024 3.1.20	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар эзэмшиж байгаа иргэн, ААН-үүдийн бүртгэлийг шинэчлэн е дугаар олгож гэрчилгээжүүлнэ.	Тооллого, кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн талбайн тоо,	Мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар эзэмшиж байгаа иргэн ААН-үүдийн 150 нэгж талбарын хүсэлтийг хүлээн авч, е дугаар олгон гэрчилгээжүүлж, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон.	100%

47	1 3	СЗДҮАХ 2021-2024 3.2.19	Бүртгэлд ороогүй хөдөө аж ахуйн үтрэмийн газруудад хэмжилт хийн баталгаажуулж газрын мэдээллийн санд бүртгэнэ.	Баталгаажуулалт хийгдсэн үтрэмийн тоо	Сумын хэмжээнд бүх үтрэмийг бүртгэлжүүлж баталгаажуулах ажил хийгдсэн байна.	Бүртгэлд ороогүй Хөдөө аж ахуйн үтрэмийн газруудыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар кадастр хийлгэж, газрын мэдээллийн санд ажлын нэгж талбар болгон оруулсан.	100%
48	1 4	СЗДҮАХ 2021-2024 3.2.20	Өвөлжөөний газрын тооллого, бүртгэл, хэмжилтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар кадастрын зураглалыг хийлгэж газрын мэдээллийн санд бүртгэж гэрчилгээжүүлнэ.	Баталгаажуулалт хийсэн өвөлжөөний тоо	Сумын хэмжээнд өвөлжөөний газруудад эзэмших эрхийн гэрчилгээ олгож баталгаажуулалт хийгдсэн байна.	Тийрэг 3 дугаар багийн 50 өрхийн өвөлжөөний газарт мэргэжлийн байгууллагаар кадастр хийлгэн газрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтээр оруулахаар бүртгэсэн байна.	100%
49	1 5	ИТХ-ын санал	Тариалангийн талбайн дундуур нийтээр зорчих орон нутгийн замыг тогтоож, тэмдэгжүүлэх, замыг засаж сайжруулах, зураг төсөв хийлгэх.	Шинээр хийгдэх зураг, төсөв	Зураг төсөв хийгдэж зам засварласан байна.	Газар тариалан эрхэлж байгаа иргэн, ААН-үүдээс ирсэн саналыг үндэслэн тариалангийн талбай дундуур явах замын гарц сайжруулах замын чиглэлийн зураг төсвийг гаргасан.	30%
50	1 6	ИТХ-ын санал	Суманд үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдээс нийгмийн хариуцлагын хүрээнд орлого төвлөрүүлж, бүтээн байгуулалт, ажлын байр бий болгоход зарцуулах, нийтэд тайлагнаж хэвшүүлэх.	Төвлөрүүлсэн орлогын хэмжээ	Нийгмийн хариуцлагын хүрээнд орлого төвлөрч, зарцуулагдсан байна	Гацуурт ХХК-ий дэмжлэгээр сумын хурдан морины шинэ замыг суваг татаж тэмдэгжүүлсэн. Мөн “Шинэбадрах” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд шинэ морь барианы газрыг тохижуулсан. “Шинэбадрах” ХХК өндөр настан 5 иргэн 20м3 болон сумын 3ш усны худагт түлээний 12м3 тус тус нийт 32м3 модыг үнэ төлбөргүй олгосон. Мөн сумын ЖДҮ эрхлэгч 3 иргэнд 18м3 цэвэр банз 15*15 харьцаатай палк 4.5м3, сумын наадмын талбайн засварт 8м3, 2-р багийн ногоон байгууламжид 7м3 банз палк, Монгол зам гүүр ХХК 10м3 брусс, Халуун усны өргөтгөлд 3м3, иргэд 50м3 зах банз, 25м3 палк, цэвэр банз 25м3, түлээ 30м3, нийт 177.5 м3 модыг хөнгөлөлттэй үнээр борлуулсан.	70%
3.2. Байгаль орчин:							
Зорилт: Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг							

бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ

51	1	СЗДҮАХ 2021-2024 3.2.1	Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх, сумын 2021-2025 он хүртэлх Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган СДОА, ХЭОН, Ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллана	Төлөвлөгөөний биелэлт, үр дүн Хяналт тавьсан аж ахуйн нэгжийн тоо	Байгаль орчныг хамгаалах багц хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх, сумын 2021-2025 он хүртэлх Ойн менежментийн төлөвлөгөөг ойн мэргэжлийн “Аглаг-Ой” ХХК-аар боловсруулан аймгийн БОАЖГазар, аймгийн Засаг даргаар батлуулсан. Ойн мэргэжлийн байгууллагуудын хэрэгжилтийн тайланг 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн ИТХ-ын 11 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж 44, 45, 46, 47-р тогтоолоор Гүн шүрэн, Баянбүрд ХЭОНөхөрлөл, “Шинэбадрах” ХХК, “Бүтээлийн нуур” ХХК-ий тайланг хангалттай гэж дүгнэсэн. Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангиар нөхөрлөлийн гэрээг батлуулж, ойн мэргэжлийн байгууллагуудад хяналт тавин ажиллаж байна	100%
52	2	СЗДҮАХ 2021-2024 3.2.2	Сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг мод, модон материалаар хангах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	Дэмжлэг үзүүлсэн иргэдийн тоо	Сумын иргэд, ЖДҮ эрхлэгчдийг мод модон материалаар хангах ажилд дэмжлэг үзүүлсэн байна.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 48 дугаар тогтоол болон иргэдээс ирсэн санал, хүсэлтийг хүлээн авч, үүний дагуу сумын удирдлагууд ойн мэргэжлийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулан мод, модон материалын үнийг тодорхой хувиар буулган тогтоосон. Сэлэнгэ аймаг дах МСҮТөвтэй Сэлэнгэ БСДОАнги хамтран ажиллах гэрээ байгуулан "Ойжуулагч мэргэжил" - ийн нэг жилийн ангид тус сумын ойн мэргэжлийн байгууллагын гэрээт ажилтан, ойн сан гэрээгээр эзэмшигч, нөхөрлөлийн нийт 16 иргэн сурч, “ОЙЖУУЛАГЧ” мэргэжилтэн болж чадавхжсан. Тус сумын ойн мэргэжлийн байгууллага “Бүтээлийн нуур” ХХК иргэдэд 165м3 цэвэр, зах банз, палкыг хөнгөлттэй үнээр борлуулсан. “Шинэбадрах” ХХК 32м3 түлээний модыг усны худаг болон өндөр настануудад үнэ төлбөргүй олгосон. Мөн сумын жижиг дунд үйлдвэр эрхлэгч 3 иргэнд 18м3 цэвэр банз 15*15 харьцаатай палк 4.5м3, сумын наадмын талбайн засварт 8м3, 2 дугаар багийн ногоон байгууламжид 7м3 банз палк,	100%

						“Монгол ЛЗ зам гүүр” ХХК 10м3 брусс, халуун усны өргөтгөлд 3м3, иргэд 50м3 зах банз, 25м3 палк, цэвэр банз 25м3, түлээ 30м3, нийт 177.5 м3 модыг хөнгөлөлттэй үнээр борлуулсан. Сумын хэмжээнд 374.5м3 мод, модон материалыг нийгмийн хариуцлагын хүрээнд сумын иргэд, өрхийн болон ЖДҮ эрхлэгчдийг мод, модон материалаар хангах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.	
53	3	СЗДҮАХ 2021-2024 3.2.4	Ойн хөнөөлт хортон шавжийн олшрол, тархалтын судалгаа, устгалын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	Талбайн хэмжээ, төрөл зүйл	Ой эрүүлжинэ.	Сумын Шүрэнгийн адаг, Мойлт нуга, Баян нуга, Эрээн хайлааст, Цог өндөр, Дээд доод хоолой зэрэг газар нутагт моносны бүгэг нийтдээ 1000 га талбайд химийн аргаар химийн бодис каратег нэг га талбайд 0.24 мл орохоор тооцоолон устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хөнөөлт шавжийн үхэл буюу техникийн үр дүн 91.7 хувьтай байна.	100%
54	4	СЗДҮАХ 2021-2024 3.2.2	Байгалийн гаралтай эмийн ургамал, жимс жимсгэнэ түүх ашиглахад БОХ-ыг сайжруулна.	Хийсэн хяналт шалгалт, илрүүлсэн зөрчил	Байгальтай харьцах иргэдийн хандлага дээшилсэн байна.	Сумын Засаг даргын шийдвэрээр хөдөлгөөнт эргүүл болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулан сар бүр хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын ажилд сумын Хэсгийн төлөөлөгч, цагдаа, багийн Засаг дарга, байгаль хамгаалагч, БОХ-ын улсын байцаагч нар хамтран ажиллаж, илэрсэн зөрчил дутагдалд арга хэмжээ авч ажилласан.	100%
55	5	СЗДҮАХ 2021-2024 3.2.2	Сумын хэмжээнд зөвшөөрөлгүй ан агнуур эрхлэх явдлыг таслан зогсоож хяналт тавьж ажиллана.	Хийсэн хяналт шалгалт, илрүүлсэн зөрчил	Зөвшөөрөлгүй хулгайн ан агнуур багассан байна.	Сумын цагдаа, БОХУБайцаагч, Ойн ангитай хамтран хууль бус мод бэлтгэл, байгалийн дагалт баялагийг түүх, хууль бус ан агнуураас сэргийлж 3 удаа хөдөлгөөнт эргүүл хийсэн. Оргих-Баруун гол чиглэлд хууль бус самар түүхийг завдсан 9 иргэнийг буцааж, Ноён уул, Бүдүүний гүүр, Далт, Баянхангай чиглэлд 2 удаа хөдөлгөөнт эргүүл хийж эрхийн бичиггүй загас барихыг завдсан 2 иргэнийг таслан зогсоож, буцаасан.	100%

56	6	СЗДҮАХ 2021-2024 3.2.6	Ой, хээрийн түймрээс урьдчилан хамгаалах хэрэгжүүлнэ.	Урьдчилан сэргийлэх санамж зөвлөмж өгсөн иргэдийн тоо	Хүнээс шалтгаалсан ой хээрийн түймэр багассан байна.	Гал түймрийн хуурайшилттай үед багийн Засаг даргатай нартай хамтран 1, 2, 3-р багийн 508 малчин өрхийн 1096 иргэнд, 46 ААН-д Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, түлээний мод бэлтгэхэд анхаарах зүйлс, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хуулиар гарын авлага бэлтгэн тарааж ой хээрийн болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, үнс нурмаа ил задгай асгахгүй байх, насанд хүрээгүй хүүхдийг түймрийн аюултай үед чүдэнз, асаагууртай явуулахгүй байхыг анхааруулж, гарын үсгээр баталгаажуулан авсан.	100%
57	7	СЗДҮАХ 2021-2024 5.2	“Тэрбум мод тарих хөдөлгөөн”-ийг эрчимжүүлж сумын төвийн айл өрх, аж ахуйн нэгж байгууллага бүрийг мод, бут, сөөг тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд анхаарч дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	Шинээр тарьсан мод, ногоон байгууламжийн хэмжээ	Сумын ногоон байгууламж нэмэгдэнэ.	Аймгийн Засаг даргын “Бүх нийтээр мод тарих арга хэмжээ зохион байгуулах” ажлын хүрээнд 5, 10 дугаар саруудад “ТЭРБУМ МОД-ЦАГААННУУР СУМ 2022” зөвлөгөөнийг сум дундын Ойн ангитай хамтран зохион байгуулж Шаамар сумын мод үржүүлгийн газруудтай хамтран тарьц суулгацны үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Нийтийн эдэлбэр газарт шинээр 5 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод 21 ширхэг, жимсний мод 69 ширхгийг, ААН-үүд гоёлын мод 82 ширхэг, жимсний мод 184 ширхгийг тус тус тарьсан Сумын хэмжээнд нийт шилмүүст мод 258 ширхэг, гоёлын мод 463 ширхэг, жимсний мод 253 буюу нийт 974 ширхгийг тарьсан.	100%
58	8	СЗДҮАХ 2021-2024 5.2	Үр үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж “Мод үржүүлэг-Ногоон байгууламж” аяныг хэрэгжүүлж ажиллана.	Нэмэгдүүлсэн ойн талбай, үр үрслэгээний тоо, хэмжээ	Үр, үрсэлгээний нөөцийг нэмэгдүүлж хамтран ажилласан байна.	Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн 0,35 сот газарт мөчрөөр болон үрээр шар хуайс 2кг, буйлс 1кг, агч 3кг тус тус үрийг тарьсан. Үүнээс буйлс 650 ширхэг, шар хуайс 9700 ширхэг, агч 8900 ширхэг нь үрсэлж ургасан. “Шүрэнгийн зам” ХХК нь хавар 232м2 талбайд өрөл 4кг, гүйлс 500гр, тэхийн шээг 2кг, агч 1кг, голт бор 1кг, буйлс 6кг үрээр тарьсан бөгөөд 85% ургалттай байна. Сум дундын Ойн	100%

						ангийн мод үржүүлгийн нөөцөд нарс 2кг, шинэс 2кг, гацуур 2кг, шар хуайс 2кг, агч 500гр, монос 2кг, хуш 5кг, “Шүрэнгийн зам” ХХК-ийн нөөцөд гүйлс 13000кг, буйлс 5кг, монос 2кг, агч 2кг тарих үр байна.	
59	9	ИТХ-ын санал	Сумын ногоон байгууламжийн усалгааг шийдвэрлэх	Шинээр хийсэн усалгааны систем	Ногоон байгууламжийн усалгааны асуудал шийдвэрлэгдсэн байна	Сумын төвийн нийтийн эдэлбэр газарт шинээр 5 ширхэг бичил цэцэрлэг 2 га-д байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 381 ширхэг, жимсний мод 69 ширхгийг тарьсан. Сумын төвийн замын урд хэсгийн ногоон байгууламжийн модыг ЕБСургууль, СӨБ, ЭМТ, замын арын хэсгийн ногоон байгууламжийг Тохижилт үйлчилгээний газар тус тус хариуцан зөөврийн усалгаа хийж байна.	70%
3.3. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ:							
<i>Зорилт:Худалдаа үйлчилгээний газруудыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангуулж, үйлчилгээний чанар, харилцааны соёл дээшлүүлнэ.</i>							
60	1	СЗДҮАХ 2021-2024 3.3.1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.	Дэмжигдсэн өрх иргэдийн тоо	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид нэмэгдсэн байна.	2022 онд шинээр “Баялаг -Ундраа” хэрчсэн гурилын цех, “Очир” талх, хэрчсэн гурилын цехүүд ашиглалтад орсон. Холбогдох бичиг баримтын бүрдлийг хянан зөвшөөрлийг өгсөн. Ажлын байрны эрүүл ахуй, стандартын шаардлагыг хангуулах, хүнсний аюулгүй байдал, дүрэм, журам холбогдох стандартыг хэрэгжүүлж зөвлөгөө, мэдээллээр ханган хяналт тавин ажилласан.	70%
61	2	СЗДҮАХ 2021-2024 3.3.2	Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	Бүтээгдэгдэхүүн ий нэр төрөл, чанар	Өрхийн үйлдвэрлэл бтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн байна	Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сурталчлах зорилгоор "ЦАГААННУУР УРГАЦ 2022" үзэсгэлэн худалдааг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, оёдол, гар урлал, хүнсний ногоо, даршилсан ногоо, мод модон эдлэл, сур суран эдлэл зэрэг 11 төрлөөр 24 өрхийн үйлдвэрлэгч 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээ танилцуулж оролцлоо. “Цагааннуур ургац-2022” үзэсгэлэн	100%

						худалдаагаар нийт 8,352,000 төгрөгийн борлуулалтыг хийсэн. Үүнээс шилдэг 5 бүтээгдэхүүнийг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан.	
62	3	СЗДҮАХ 2021-2024 3.3.4	Худалдаа үйлчилгээний салбарын орчин нөхцөлийг сайжруулан үйлчилгээний соёл, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавина.	Хяналт шалгалтын тоо	Эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчилсэн байна.	Суманд хүнсний бараа, түүхий эдийн аюулгүй байдлыг хангуулах, хүнсээр дамжих элдэв халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ажлын хэсэг гарч 3 удаагийн хяналт шалгалтыг хийсэн. Нийт давхардсан тоогоор 22 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. Шалгалтаар 74 нэр төрлийн /2сая 300мянга/ төгрөгний хүнсний бүтээгдэхүүн лангуунаас татуулан буцаалт хийлгүүлж, 120 гаруй нэр төрлийн /1 сая 970 мян/ төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг байгууллагын дотоод хяналтын журмын дагуу устгуулж ажилласан. Шалгалтаар 194 зөрчил илрүүлэн 180 буюу 92.7 хувийг арилгасан. Илэрсэн зөрчлийн 40 хувь нь шошгын мэдээллийг бүрэн тусгаагүй, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан, гарал үүсэл нь тодорхойгүй, хадгалалтын горим алдагдсан, хугацаа дууссан зэрэг зөрчлүүд илэрч байна.	100%
3.4.Хөрөнгө оруулалт, дэд бүтэц:							
Зорилт:Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, сумын тохижилтыг сайжруулан, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.							
63	1	СЗДҮАХ 2021-2024 3.4.4	Сумын төвийн 154 гэрэлтүүлгийн урсгал засварын ажлыг хийж бүрэн ашиглалтад оруулна.	Засварласан гэрэлтүүлгийн тоо, чанар	Сумын тохижилт өнгө үзэмж сайжирна.	Аймгийн замын сангийн хөрөнгөөр 32,5 сая, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 13,9 сая нийт 46.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр “Авто мастер төв” ХХК шалгаран 100 хувь хийж гүйцэтгэсэн.	100%
64	2	САЖХТ 8.1.8, СЗДҮАХ 2021-2024 3.4.5	Сумын төвийн 2,4 км хатуу хучилттай замыг орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгөөр үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.	Шинээр тавигдсан хатуу хучилттай замын чанар, хэмжээ	Иргэдийн ая тухтай амьдрах, зорчих нөхцөл сайжирна.	Улсын төсвийн хөрөнгөөр нийт 925,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр “СЭЛЭНГЭ-АЗЗА ТӨХК” шалгарч энэ онд замын чиг сэргээн, далангийн ажлыг эхэлсэн 2023 онд ажил хийгдэж дуусна.	50%

65	3	СЗДҮАХ 2021-2024 3.4.7	2-р багийн хүүхдийн тоглоомын талбайн ажлыг дуусгаж ашиглалтанд оруулна.	Шинээр хийгдсэн бүтээн байгуулалтын тоо, хэмжээ	Хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж нөхцөл дээшилнэ.	Тендерт шалгарсан байгууллагын хариуцлагаас шалтгаалан гүйцэтгэл дутуу хийгдсэн.	30%
66	4		Сумын баяр наадмын талбайн сүүдрэвч засварлана.	Талбайн засварын чанар,	Наадмын талбайн сүүдрэвч засварлагдсан байна.	Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 28,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр “ Бумт оргил констракшн ХХК” 100 хувь хийж гүйцэтгэсэн.	100%
67	5	СЗДҮАХ 2021-2024 3.4.9	Нийтийн боловсон бие засах газар /Сити ОО/шинээр бий болгоно.	Нийтийн боловсон бие засах газартай болсон эсэх	Хөрсний бохирдол буурч, тохижилт сайжирна.	Нийтийн боловсон бие засах газар /Сити нойл/-ын ажлыг сумын ОНХС-ийн хөрөнгө 77,9 сая төсөвт өртөгтэйгээр “Баяжих ундрага ХХК” шалгарч ажил 50 хувьтай явагдаж байна.	50%
68	6	СЗДҮАХ 2021-2024 3.4.13	Сумын 1 дүгээр багийн нутаг Гэр чулууны давааны авто замыг сайжруулж дайрган хучилт тавина.	Давааны замын чанар, хэмжээ	Давааны зам засагдсан байна.	Гэр чулууны давааны авто замыг сайжруулж, дайрган хучилт хийх ажлыг сумын ОНХС, Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр 178,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК 100 хувь гүйцэтгэсэн.	100%
69	7	СЗДҮАХ 2021-2024 3.4.4	Сумын ногоон байгууламжийн тохижилтын ажил/2, 3 дугаар багийг холбосон 500 метр явган хүний зам/-ыг хийж гүйцэтгэнэ.	Шинээр хийгдсэн замын чанар, хэмжээ	Сумын төвийн тохижилт, иргэдийн ая тухтай зорчих нөхцөл дээшилнэ.	Ногоон байгууламжийн тохижилтын ажлыг сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 78,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр “Сэлэнгэ-Таванхан” ХХК 100 хувь хийж гүйцэтгэн ашиглалтад өгсөн.	100%
70	8	СЗДҮАХ 2021-2024 3.4.15	Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг хашаажуулж камержуулна.	Баригдсан хашаа камержуулалтын чанар, стандарт	Хогийн цэгийн эмх цэгц сайжирна.	Сумын нэгдсэн хогийн цэгийг хашаажуулж, камержуулах ажлыг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 168,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр “Баяжих ундрага ХХК” 100 хувь хийж гүйцэтгэсэн.	100%
71	9	СЗДҮАХ 2021-2024 3.4.16	Хатуу хучилттай зам дагуу /фермийн урд талаар/ хашаа барьж мод тарина.	Тарьсан модны тоо, хашааны хэмжээ	Сумын өнгө үзэмж сайжирч, ногоон байгууламж нэмэгдэнэ.	Сумын төвийн нийтийн эдэлбэр газарт шинээр 4 хашаа барьж 258 ш нарс тарьсан.	100%
72	10	СЗДҮАХ 2021-2024 3.4.17	Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км	Замын ажлын явцын гүйцэтгэлийн	хатуу хучилттай замын ажил хийгдсэн байна.	“Монгол ЛК зам гүүр” ХХК ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэж байгаа бөгөөд үндсэн далан, гүүрний ажил 95 хувьтай, асфальт	30%

			авто замын ажлыг дэмжиж, хамтран ажиллах. Сумын төвийн хатуу хучилттай замыг төв замтай холбох ажлыг хэрэгжүүлнэ.	хэмжээ		хучилтын ажил 5 хувьтай явагдаж байна.	
73	11	СЗДҮАХ 2021-2024 3.4.4.	Сумын 3-р баг хонхорын чиглэлд 900 метр сайжруулсан авто зам шинээр тавина.	Замын ажлын явцын гүйцэтгэлийн чанар, хэмжээ	Сайжруулсан авто замын ажил хийгдсэн байна.	“Монгол ЛЗ зам гүүр ХХК”-ийн хөрөнгөөр тавигдах “Хонхор” чиглэлийн сайжруулсан замын ажил улаан шугам татаж чиг тавьсан.	30%
74	12	СЗДҮАХ 2021-2024 3.4.4.	Сумын 3-р баг хонхорын чиглэлд сайжруулсан авто зам дагуу шинээр гэрэлтүүлэг хийнэ.	Засварласан гэрэлтүүлгийн тоо	Сумын тохижилт өнгө үзэмж сайжирна.	Аймгийн замын сангийн хөрөнгөөр хийгдэх “Гэрэлтүүлэг”-ийн ажлын тендерт “Хөтөл цэнэг ХХК” шалгарч, гэрээ хийгдсэн.	30%
75	13	СЗДҮАХ 2021-2024 3.4.11	Золбин нохой устгах ажлыг зохион байгуулна	Устгасан нохойн тоо	Золбин нохой, муур багасна.	2022 онд “Цагааннуур тохижилт” ОНӨААТҮГ, ИТХ, байгаль хамгаалагч нар хамтран золбин нохой устгалын ажлыг улирал бүр зохион байгуулж нийт 180 нохой устган зориулалтын ухсан нүхэнд ариутгал халдваргүйтгэл хийн булсан.	100%
76	14	СЗДҮАХ 2021-2024 3.4.21.	Сумын ЗДТГ-ын байрны урсгал засварыг хийнэ.	Засвар хийгдсэн эсэх	Засварын ажил хийгдсэн байна	Сумын төсвийн хөрөнгөөр 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр “Баяжих ундрага ХХК” шалгаран 100 хувь хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100%
77	15	ОНХС-д иргэдийн гаргасан санал	Сургуулийн хичээлийн Б байрны агааржуулалтыг ОНХС-ийн хөрөнгөөр шинэчлэн засварлана.	Засвар хийгдсэн эсэх	Засварын ажил хийгдсэн байна	Сургуулийн хичээлийн Б байрны агааржуулалтыг сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 39,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр “Эйр вектер ХХК” 100 хувь хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100%
78	16	СЗДҮАХ 2021-2024 2.2.9.	Аймгийн хөрөнгө оруулалтаар ЕБС-д биологийн кабинет байгуулна.	Гүйцэтгэлийн хувь	Кабинет байгуулагдсан байна	Аймгийн төсвийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр ЕБС-д биологийн кабинет байгуулах эд хогшил нийлүүлэхээр “Мэгсим консалтинг” ХХК-тай гэрээ хийсэн.	30%
79	17	СЗДҮАХ 2021-2024 3.4.19.	Сумын төвийн зарим айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг цэвэр ус, дулааны шугамд холбоно.	Шинээр холбогдсон өрх ААН-н тоо	Айл өрх, ААН-д шинээр цэвэр ус, дулаанд холбогдсон байна	2022 онд шинээр 3 өрх, 1 байгууллага дулаанд, 5 өрх цэвэр усны байнгын шугамд холбогдсон.	100%
80	18	ИТХ, иргэдийн	Дулааны төвийн уурын зуухыг шинэчлэн байгуулна.	Барилга баригдсан эсэх	Уурын зуухны шинэ барилга	Сумын дулааны төвийг хариуцагч “Эл Си Би ХХК” нь өөрийн хөрөнгө 450,0 сая төгрөгөөр	70%

		санал.			баригдсан байна.	байр барьж, шинээр 2 зуух суурилуулан ашиглалтад оруулан ажиллаж байна.	
81	19	СЗДҮАХ 2021-2024 4.2.6.	Сумын төвийн камержуулалтыг засварлаж шинэчлэх, иргэн ААН-үүдийг камержуулах ажлыг дэмжих	Шинээр засварлагдсан камерийн тоо	Камержуулалт бүрэн хийгдэж нэгдсэн хяналт цагдаагийн албанд тавигдсан байна.	Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 28,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр “Баяжих ундрага ХХК” төв доторх зам дагуу 10 байршилд 16 камерыг шинээр байрлуулан хүлээлгэж өгсөн.	100%
82	20	ИТХ-ын санал	Хурдан морины уралдааны замыг шинэчлэн тогтоож, баталгаажуулах.	Баталгаажуулсан замын хэмжээ	Хурдан морины шинэ зам баталгаажсан байна.	Сумын ИТХ-ын тогтоолоор Тийргийн голоос сумын төвийн шинэ морь барианы газар хүртлэх 18 км замыг “Гацуурт ХХК”-ийн техникийн дэмжлэгтэйгээр /автогрэйдер/ суваг татан баталгаажуулсан.	100%
3.5. Санхүү, төсвийн зохицуулалт:							
<i>Зорилт:Төсвийн ил тод байдал, сахилга батыг хангаж, төсвийн төлөвлөлтийн оновчтой хуваарилалт, зарцуулалтыг удирдана.</i>							
83	1	СЗДҮАХ 2021-2024 3.5.6.	“Иргэн та эдийн засагч” арга хэмжээг зохион байгуулна.	Оролцсон иргэн ААН-н тоо	Иргэдийн санхүүгийн боловсрол дээшилсэн байна.	“Иргэн та эдийн засагч” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу ХАА-н мэргэжилтэнтэй хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 30 сурагчид 50 малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 42 ААН-ын албан хаагчдад нийгмийн даатгал, татварын цахим үйлчилгээ, хөдөө аж ахуйг дэмжих сангийн зээлийн талаарх ойлголт, статистикийн боловсрол болон санхүүгийн эдийн засгийн мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулсан.	100%
84	2	СЗДҮАХ 2021-2024 3.5.1.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн байгууллагуудын шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулах, түүнд тавих хяналтыг сайжруулна.	Төсвийн ил тод байдлыг хангасан эсэх	Төсвийн ил тод байдал хангагдана.	Шилэн дансны нэгдсэн сайтад /shilendans.gov.mn/ мэдээллийг үнэн зөв бодитой тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэхийг байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт тухай бүр сануулж төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллагуудад 1, 2, 3 дугаар улирлын хяналт шалгалтыг хийж гарсан алдаа дутагдлыг арилгах цаашид давтан гаргахгүй байх үүрэг чиглэл өгч ажилласан. 11 дүгээр сарын байдлаар ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны цахим	100%

						хуудсанд байршуулах мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	
85	3	СЗДҮАХ 2021-2024 3.5.2.	Татварын бааз суурийг нэмэгдүүлж улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх	Татварын орлого бүрдүүлэлтийн хувь	Татвар төлөгчдийн тоо, орлогын хэмжээ нэмэгдэнэ.	2022 онд улсын төлөвлөгөө 264,045.2 мянган төгрөг төвлөрөхөөс 592,528.2 мянган төгрөг буюу 224,4%, аймгийн төлөвлөгөө 169,493.3 мянган төгрөг төвлөрөхөөс 189,549.7 мянган төгрөг буюу 111.8%, сумын төлөвлөгөө 852,424.6 мянган төгрөг төвлөрөхөөс, 836,527.9 мянган төгрөг буюу 98.1% нийт 1,285,963.1 мянган төгрөг төвлөрөхөөс 1,618,605.8 мянган төгрөг буюу 125.9% биелэсэн байна.	100%
86	4	СЗДҮАХ 2021-2024 3.5.2	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Е баримт олгох татвар төлөгчийн тоо	Татвар төлөгчдийн тоо нэмэгдэнэ.	Газар тариалан эрхэлдэг 23 ААН, 16 иргэн, худалдаа үйлчилгээ эрхэлдэг 8 ААН И-баримт тогтмол хэвлэж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг тогтмол хийж байна.	100%
87	5	СЗДҮАХ 2021-2024 3.5.3.	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	Цалингийн нэгдсэн системд холбогдсон эсэх	Мэдээллийн санд бүрэн холбогдсон байна.	Хүний нөөц удирдлага мэдээллийн санд бүртгэлтэй төрийн албан хаагчдын мэдээллийг тухай бүр шалгаж, төрийн албаны цалингийн нэгдсэн системээс боловсруулагдаж гарсан төлбөрийн хүсэлтийг үндэслэж цалингийн олгож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавин, цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгон ажиллаж байна.	100%
88	6	СЗДҮАХ 2021-2024 3.5.4.	Статистикийн мэдээ, тооллого, судалгааг үнэн, бодитой гаргана.	Статистикийн мэдээ, судалгааны чанар, тоо хэмжээ	Статистик тоо мэдээ үнэн зөв гарсан байна.	Албан ёсны 43 төрлийн статистик мэдээг нийт 165 удаагийн давтамжтайгаар холбогдох мэргэжилтнээр үнэн зөв бодитой гаргуулан графикийн дагуу цаг хугацаанд нь аймгийн статистикийн хэлтэст цаасаар болон онлайнаар хүргүүлсэн.	100%
89	7	СЗДҮАХ 2021-2024 3.5.7	“Сум хөгжүүлэх сан”-гийн зээл олгох ажлыг чанаржуулж, эргэн төлөлтийг сайжруулна.	Зээлийн төлөлтийн тоо, хэмжээ	Зээлийн эргэн төлөлт сайжирна.	Хоршоо дэмжих сангийн зээлийн үлдэгдэл 125,831,388 төгрөг байснаас үндсэн зээл 34,777,308 төгрөг, хүү 2,152,627 төгрөг, алданги 3,457,433 төгрөг нийт 40,387,438	100%

						төгрөг төлөгдсөн байна. 11 дүгээр сарын байдлаар үндсэн зээлийн үлдэгдэл 82,964,262 төгрөг, хүү 2,254,688 төгрөг, алданги 225,000 нийт 85,443,950 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд “Хоршоог хөгжүүлэх сан”-гийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлд 6 төсөл ирсэн боловч зээл олгох журмын шаардлага хангаагүй тул олгогдоогүй.	
90	8	ИТХ-ын санал	Сумын нутаг дэвсгэрт амьдарч байгаа гадны иргэдийн малаас татвар авах боломжийг судалж хэрэгжүүлэх	Татвар төлөх иргэд, малын тоо	Гадны иргэдийн малаас татвар авсан байна.	Сумын нутаг дэвсгэрт амьдарч байгаа малчин өрхийн судалгааг гаргасан. Нийт Тийрэг, Атар чиглэлд 100 өрх амьдарч байгаа бөгөөд 2023 оноос эдгээр малчин өрхүүдийн татварыг суманд төвлөрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.	0
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
4.1.Нутгийн захиргаа.							
<i>Зорилт: Хариуцлагатай, шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэнэ.</i>							
91	1	СЗДҮАХ 2021-2024 4.1.3	E-Mongolia цахим үйлчилгээний талаар сурталчилан иргэдэд цахим үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.	Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний тоо	Иргэд төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцөл сайжирна.	E-mongolia цахим үйлчилгээний талаар сумын веб сайт болон цахим хаягаар дамжуулан сурталчилан ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар оператороор дамжуулан 154, гар утасны апплейкшнаар зөвлөгөө мэдээлэл, туслалцааг 184 иргэнд үзүүлсэн.	100%
92	2	СЗДҮАХ 2021-2024 4.1.2	Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, төрийн бүх шатны байгууллагад суралцагч байгууллагын соёлыг бэхжүүлнэ.	Нийгмийн баталгаа хөтөлбөр, сургалтын тоо	ТАХ-ын нийгмийн баталгаа хангагдсан байна.	ЗДТГ-ын барилгын их засварыг хийж ашиглалтад оруулсан. Сумын төрийн бүх байгууллагууд ажилтнуудыг ажлын байранд суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Эрүүл мэндийн төвийн ажиллагсадын байрны суурь тавигдан баригдаж байгаа бөгөөд “Төрийн орон сууц” корпорацтай хамтран 2 өрөө байрыг гэрээний дагуу худалдан авч шинээр суманд ирж ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг түр суулгаж байна.	100%
93	3	СЗДҮАХ	Иргэдийн санал, өргөдөл	Шийдвэрлэсэн	Иргэдийн санал,	3 дугаар улирлын байдлаар сумын төр,	100%

		2021-2024 4.1.4	гомдлыг шийдвэрлэх баримтлан “Таныг сонсьё” арга хэмжээг зохион байгуулна.	шуурхай зарчмыг зохион	санал, өргөдөл, гомдлын тоо, захиргааны шийдвэр гаргахад оролцсон иргэдийн тоо	өргөдөл, гомдол шуурхай шийдвэрлэгдэж, захиргааны шийдвэр гаргахад иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.	төсвийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 36 өргөдөл гомдол ирүүлсэн бөгөөд 100 хувь хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн.	
94	4	СЗДҮАХ 2021-2024 4.1.5	Төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа болон хөгжлийн бодлогын баримт бичиг төлөвлөлт, явц, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг тооцох		Хяналт шалгалтын тоо	Хөгжлийн бодлогын баримт бичиг төлөвлөлт, биелэлт зохих үр дүнд хүрсэн байна.	Төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан болон бодлогын баримт бичгийн биелэлтийг улирал, жилээр авч нэгтгэн, аймгийн ЗДТГ, сумын ИТХ-д тайлагнан ажиллаж байна. 2022 онд Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитаас 2021 оны санхүүгийн гүйцэтгэлийн аудит, Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын албаны төлөвлөгөөт хяналт шалгалт тус бүр 1 удаа, 2021, 2022 оны эхний хагас жилийн сумын дотоод хяналт шалгалтыг 3 удаа хийгдсэн.	100%
95	5	СЗДҮАХ 2021-2024 4.1.7	Иргэд, төр төсвийн байгууллагын ажилтнуудад зориулсан хувь хүний хөгжил, амдрах ухааны сургалтыг мэргэжлийн чадварлаг багш нарын оролцоотойгоор зохион байгуулна.		Сургалтын тоо Оролцогчдын тоо	Иргэд, төсвийн байгууллагын ажилтнуудад сургалт зохиогдсон байна.	Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмэгтэйчүүдээ соён гэгээрүүлэх, хөгжүүлэх, тэдний дуу хоолойг сонсохоор зохион байгуулагдаж буй "Хандлагаа өөрчилж, хамтдаа хөгжье" чуулга уулзалтыг зохион байгууллаа. Чуулга уулзалтаар Лектор Н.Алтанцоож “Харилцаа” сэдэвт сэтгэл зүйн сургалтыг явууллаа. Сумын Засаг даргын Тамгын газрын 28 албан хаагчийг Монголын нутгийн удирдлагын холбооны лектор багш нараар “Хувь хүний хөгжил, хандлага” “Төрийн албаны ёс зүй” сэдэвт сургалтуудад хамрууллаа.	100%

96	6	СЗДҮАХ 2021-2024 4.1.8	Сумын ИТХ, ЗДТГ-аас улирал бүр иргэдтэй уулзалт зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажиллана.	Хамрагдсан иргэдийн тоо, санал	Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна	2021 оны ажлын үр дүнг тайлагнах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх зорилгоор 02 дугаар сард сумын ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ, Эрүүл мэндийн ажилтнууд хамтран 8 хэсэг болж 1, 3 дугаар багийн 380 малчин өрхөөр явж өвөлжилт хаваржилтын байдалтай танилцан, сумын ЗДТГ-аас 2021 онд зохион байгуулсан ажлын тайлан болон цаг үеийн ажлын мэдээлэл хүргэж ажиллалаа. Сумын Засаг дарга 1 дугаар улиралд 1,2,3 дугаар БИНХ-аар, 2 дугаар улиралд төр төсвийн байгууллагуудын албан хаагчидтай, 3 дугаар улиралд 2,3 дугаар багийн өдөрлөгөөр малчид иргэдтэй уулзалт зохион байгуулж ажиллалаа.	100%
97	7	СЗДҮАХ 2021-2024 4.1.9	Суманд үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ын удирдлагын зөвлөгөөнийг сар бүр зохион байгуулж, цаг үеийн мэдээллийг танилцуулан тайланг сонсож хэлэлцэнэ.	Уулзалт, зөвлөгөөний тоо	Удирдлагуудын зөвлөгөөнийг тогтмол хийж хэвшсэн байна.	Суманд үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ын удирдлагын зөвлөгөөнийг улирлд 1 удаа хийж, цаг үеийн мэдээллийг танилцуулж ажилласан.	30%
98	8	СЗДҮАХ 2021-2024 4.1.10.	Сумын ИТХ, ЗДТГ-с зохион байгуулсан ажлын талаар сонин, товхимол гаргаж өрх бүрт хүргэнэ.	Гаргасан сонин, товхимолын тоо	Иргэд мэдээлэл авсан байна.	2022 онд суманд хийгдсэн бүтээн байгуулалт, төрийн үйлчилгээ, статистик тоо мэдээллийг улирал бүр нэгтгэн гаргадаг “Нуурын мэдээ” сонины 1,2,3-р улирлын хэвлэлт, 2021 оны сумын жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 02 дугаар сард 1000 ширхгийг хэвлэж иргэдэд тараасан.	100%
4.2. Хууль эрх зүй:							
<i>Зорилт: Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг дээшлүүлж иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.</i>							
99	1	СЗДҮАХ 2020-2024 4.2.1	Хууль сурталчлах, таниулах ажлын хүрээнд сургалт сурталчилгаа зохион байгуулж олон нийтэд хууль зүйн мэдээллийг цахим болон гарын авлага, мэдээллийн самбараар	Сургалт, гарын авлага, мэдээллийн тоо	Иргэд анхан шатны эрх зүйн мэдээллийг өөрт ойр сувгаас түргэн шуурхай авна.	Иргэдийн эрх зүйн чадамжийг дээшлүүлэх зорилгоор нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын хуулийг танилцуулах сургалт уулзалтыг 2 удаа зорилтот бүлгийн иргэдэд, 1, 2, 3-р багийн өдөрлөгөөр дамжуулан Газрын тухай хууль, Татварын тухай хуулиар 615 иргэнд мэдээлэл хийхийн	100%

			шуурхай хүргэнэ.			зэрэгцээ Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хуулиар гарын авлага бэлтгэн 508 малчин өрхийн 1096 иргэнд, 46 ААН-д хүргэсэн. Мөн цахим орчноор дамжуулан Авлигын эсрэг хууль, гэр бүлийн тухай хууль, малын хулгайн тухай хуулиас 21 удаагийн нийтлэлээр танилцуулсан.	
100	2	СЗДҮАХ 2020-2024 4.2.2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангана.	Гэмт хэрэг, зөрчлийн тоо	Гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурсан байна.	2022 оны 10 дугаар сарын байдлаар 24 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд өмнөх оноос 41.2%-р өссөн байна. Үүнд хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 1, хүний эрүүл мэндэд хохирол учруулах 5, бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 1, хулгайлах гэмт хэрэг 4, залилах гэмт хэрэг 5, мал хулгайлах авилгалын 1, хууль бусаар мод бэлтгэсэн, хөдөлгөөний аюулгүй байдлын 1, бусад 2 гэсэн гэмт хэргүүд бүртгэгдээд байна. 2021 онд Мал хулгайлах гэмт хэрэг 6 бүртгэгдэж байсан бол 2022 оны 11 дүгээр сарын байдлаар хулгайлах 1 гэмт хэрэг, байгаль орчны эсрэг зөрчил 4, гэмт хэрэг 6 бүртгэгдсэн.	70%
101	3	СЗДҮАХ 2020-2024 4.2.3	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийтэд түгээн авилга, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ.	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил, арга хэмжээг улирал бүр зохион байгуулна	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн сурталтад давхардсан тоогоор 86 төрийн албан хаагч хамрагдсан. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын хор аюулыг ухуулан таниулах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Зөв зөвд шударга зөв” нөлөөллийн аянд нэгдэж аяны талаарх мэдээллийг иргэдэд цахимаар хүргэсэн. Соён гэгээрүүлэх аяны хүрээнд 12 төрлийн сурталчилгааны хуудас, 9 төрлийн зөвлөмж, 14 видео бичлэгийг сумын цахим хуудаст байршуулсан.	100%
102	4	СЗДҮАХ 2020-2024 4.2.5	Өмчийн хулгай, малын хулгай, байгаль орчны эсрэг гэмт хэргийн гаралтыг	Гэмт хэргийн тоо	Гэмт хэргийн гаралт буурсан байна.	Сумын гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гишүүд нийт 200 гаруй малчин өрхөөр явж малын хулгайгаас болон	70%

			бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.			бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл хийж гарын авлага тараалаа. Цагдаагийн байгууллагаас Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа "Мал-Мах-2022" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 1, 2, 3 дугаар багийн 113 малчин болон мал бүхий иргэдэд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчдын бүлэг нөхөрлөл байгуулах хэрхэн ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажилласан.	
103	5	СЗДҮАХ 2020-2024 4.2.6	Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэрэлтүүлэг, гарц, камер, хурд сааруулагчтай болгоно.	Шинээр хийсэн гэрэлтүүлэг, гарц, камер, хурд сааруулагчийн тоо	Хүүхдийн аюулгүй зорчих орчин сайжирна.	Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын төв зам дагуу 10 байршилд 16 камерыг шинээр байрлуулсан. Мөн гэрэлтүүлгийг сайжруулж сумын төвийн 154 гэрэлтүүлгийн урсгал засварын ажлыг хийж бүрэн ашиглалтад оруулсан.	100%
104	6	САХТЖҮЧ 5.5	"Иргэн таны хүний эрхийн боловсролд" арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	"Таны хүний эрхийн боловсролд" цахим нийтлэлийг 10 удаа цувралаар олон нийтэд хүргэсэн байна.	"Иргэн таны хүний эрхийн боловсролд" цахим нийтлэлийг 5 удаа цувралаар олон нийтэд хүргэж ажилласан.	70%
4.3.Батлан хамгаалах бодлого, гамшгаас хамгаалах							
Зорилт:Орон нутгийн хамгаалалт, батлан хамгаалах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлнэ.							
105	1	СЗДҮАХ 2020-2024 4.3.1	Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	Цэргийн албанд тэнцсэн иргэдийн тоо	Цэргийн алба хаах хүсэл, сонирхолтой иргэдийн тоо нэмэгдэнэ.	2022 оны 1-р ээлжийн цэрэг татлагад 35 залуу хамрагдснаас 1 иргэн тэнцсэн, 2-р ээлжийн цэрэг татлагад 50 залуу хамрагдснаас 18 иргэн тэнцэж цэргийн албанд татагдсан. Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын нэрэмжит сумын аварга шалгаруулах Цэрэг-Спортын "Дөл" тэмцээн	100%

						2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр суманд явуулж улмаар бүсийн сумдаас шалгарсан багуудын дунд Сэлэнгэ бүсийн сумдуудын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.	
106	2	СЗДҮАХ 2020-2024 4.3.2	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, бүх нийтийн оролцоотойгоор орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, хамгаалах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	ОНХ-ын нийт томилгоот бүрэлдэхүүний 5 хув сургалтад хамрагдсан байна.	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд тодотгол хийж, хуулийг олон нийтэд цахимаар танилцуулсан.	100%
107	3	СЗДҮАХ 2020-2024 4.3.4	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулж, ГХШ-ын бэлэн байдлыг ханган, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо	Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдсан байна.	Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль 06 сарын 3-5-ны өдрүүдэд “Танхимын сургалт”, “Бэлэн байдлын үзлэг”, “Штабын дадлага”, “Дадлага, сургууль” гэсэн үндсэн дөрвөн хэсэгтэйгээр явагдлаа. Штабын дадлага сургууль нь сумын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин болсон үеийн удирдлагын хариу арга хэмжээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн анги, албадын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, өгөгдсөн цагийн байдлын дагуу бүлгээр ажиллах дадлагаар явагдлаа. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн иргэдийг аюулгүй нүүн шилжих дадлага суруульд нийт 689 иргэн хамрагдлаа. 2022 оны 06 дугаар сарын 05-ны Сумын улаан загалмайн анхан шатны хороо, сумын ЗДТГ хамтран “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-г зориулан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжин идэвхжүүлэх, хамтран ажиллах “Бэлэн бай” сургалт зохион байгуулж 15 иргэн хамрагдсан.	100%

108	4	СЗДҮАХ 2020-2024 4.3.6	Суманд гамшгаас хамгаалах Эрэн хайх аврах салбар анги байгуулах саналыг холбогдох байгууллагад уламжлан салбар анги байгуулах бэлтгэл ажлыг хангана.	Уламжилсан эсэх	Зохих шатанд уламжлагдан шийдвэрлэгдсэн байна.	Суманд гамшгаас хамгаалах Эрэн хайх аврах салбар анги байгуулах саналыг Аймгийн Онцгой байдлын газар, Аймгийн Засаг даргаар дамжуулан МУ-ын Засгийн газарт санал хүргүүлсэн. Зураг төслийн ажил хийгдэж байна.	30%
-----	---	------------------------------	--	-----------------	--	--	-----

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**СУМЫН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН НЭГТГЭЛ**

2022.12.09

Цагааннуур сум

Зорилт арга хэмжээ	Заалт	2022 он /хувь					Дүн
		0	30	50	70	100	
НЭГ.“КОВИД-19” ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
Зорилт 1	2					2	100%
Дүн	2					2	100%
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
Эрүүл мэнд	5					5	100%
Боловсрол	6	2				4	66.6%
Биеийн тамир, спорт	5					5	100%
Соёл, урлаг	5	2	1			2	46%
Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого	7			2	1	4	81.4%
Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал	4				1	3	92.5%
Дүн	32	4	1	4	2	21	81%
ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
Хөдөө аж ахуйн бодлого	16	3	3		4	6	60.6%
Байгаль орчин	9				1	8	96.6%
Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ	3				1	2	90%
Хөрөнгө оруулалт, дэд бүтэц	20		5	2	1	12	76%
Санхүү, төсвийн зохицуулалт	8	1				7	87.5%
Дүн	56	3	7	3	8	35	82.1%
ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
Нутгийн захиргаа	8		1			7	91.2%
Хууль эрх зүй	6				3	3	85%
Батлан хамгаалах бодлого, гамшгаас хамгаалах	4		1			3	82.5%
Дүн	18		1		1	16	86.2%
Нийт дүн	108	7	9	7	11	74	87.3%

НЭГТГЭЛ ХИЙСЭН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.АЛТАНЗОРИГ

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Ц.БАЯНБААТАР

